



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 214

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон нийт 700,000,000.00 (долоон зуун сая) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Говьсүмбэр аймгийн Татварын хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Татварын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Занданбат, Говьсүмбэр аймгийн Татварын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Энх-Оюун нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001763

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн
24 дугаар тогтоолын хавсралт



Говьсүмбэр аймгийн Татварын хэлтсийн үндсэн
хөрөнгөд бүртгэж авах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Байршил	Хэмжээ м.кв
1	Зоорийн давхар	2015	169,111,302.85	Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3-р баг, 15-р байрны зүүн урд талд	196
2	1 давхрын барилга	2015	164,797,239.00		191
3	2 давхрын барилга	2015	165,660,051.77		192
4	3 давхрын барилга	2015	157,031,924.07		182
5	Авто гарааш	2015	43,399,482.31		50.3
	Дүн		700,000,000.00 (долоон зуун сая)		811.30